



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

“МИК актив дөрөв” ХХК-д Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
хараат бус гишүүдээ томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 3.12 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК актив дөрөв” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр Цэдэвийн Цолмон, Ёндонгийн Мөнхбат, Чимэд-Очирын Баяртуул нарыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. “МИК актив дөрөв” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Цэдэвийн Цолмон, Ёндонгийн Мөнхбат, Чимэд-Очирын Баяртуул нарт холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдахаас өмнө “МИК актив дөрөв” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр, түүний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй байхыг дурдсугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



3. НАРАНТУЯА

030536